


БАТЛАВ:

ЗАХИАЛАГЧ:



НИЙЛҮҮЛЭГЧ:

“АЙ ЭМ ТЕХ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



**ШИНЭ КОРОНАВИРУСТ ХАЛДВАРЫН ҮЕД ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
/БАГЦ-1: ЭМНЭЛГИЙН ОР/ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ**

Дугаар № **235**

Улаанбаатар хот

Нэг талаас “Эрүүл мэндийн яам” (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “Ай Эм Тех” ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 6 дугаар сарын 26-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Шинэ коронавируст халдварын үед эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж /Багц-1: Эмнэлгийн ор/ -ийг нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрч гэрээ байгуулав. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг 492,000,000₮ /Дөрвөн зуун ерэн сая/ төгрөгөөр Засгийн газрын нөөц хөрөнгөөс санхүүжүүлнэ. 2020 онд санхүүжих дүн 492,000,000₮ /Дөрвөн зуун ерэн сая/ төгрөгийг тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгснөөс хойш 30 хоногийн дотор нийлүүлэгчийн дансанд шилжүүлнэ.

4. Нийлүүлэгч нь доорх нэр төрлийн барааг, талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажсанаас хойш 14 хоногийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

№	Барааны нэр	Барааны гарал үүсэл	Марк	Тоо ширхэг
	1	2	3	4
1	Өвчтөний ор зөөлөн эдлэл, шүүгээний хамт /механик/	БНХАУ	A-17	440
2	Өвчтөний ор зөөлөн эдлэл, шүүгээний хамт /функциональ/	БНХАУ	DA-4	100

5. Захиалагч болон нийлүүлэгч байгууллагын зүгээс үл хамаарсан хүчин зүйлсийн улмаас гэрээний зарим зүйл заалт биелүүлэх хугацаа хойшлогдсон тохиолдолд хоёр тал харилцан тохиролцож, зөвшилцөн шийдвэрлэнэ.

6. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Бусад шаардлагатай баримт бичиг;
Тендерийн баталгаа;
Тендер ба үнийн хуваарь;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь;
Баталгаат хугацааны мэдэгдэл /албан тоот/
Гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн тухай мэдэгдэл /албан тоот/

7. Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

8. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

9. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

10. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Хуулийн хэлтсийн дарга

.....

М.Ганзориг


НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Борлуулалтын ахлах менежер


АЙ ЭМ ТЕК ХХК
ИМТЕГ
ЭРҮҮЛ МЭНДИЙГ ТЕХНОЛОГИТОЙ ХОЛВОЕ
УЛААНБААТАР ХОТ
1118261630 ☎ 5730163 АМТ02160


Баярцаг
Б.Баярцогт
Б.Халиунаа
Б.Халиунаа

Хөрөнгө оруулалтын хэлтсийн
даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч



Т.Бямбасүрэн
Хуулийн хэлтсийн гэрээний
мэргэжилтэн


Эмнэлгийн тоног төхөөрөмжийн
инженер



Г.Хишигжаргал


Хөрөнгө оруулалтын хэлтсийн
ахлах мэргэжилтэн

Д.Мөнхцэцэг



Г.Бат-Эрдэнэ

Хаяг: Эрүүл мэндийн яам, Засгийн
газрын VIII байр, 1 давхар 106 тоот
өрөө Улаанбаатар-48, Олимпын
гудамж-2
Утас: 51-263631, Факс: 323541

Хаяг: "АЙ ЭМ ТЕК" ХХК, Аюуд тауер,
8 давхар, 803 тоот, Олимпийн
гудамж, Сүхбаатар дүүрэг, 1-р
хороо, Улаанбаатар хот
И-мэйл: khaliunaa@imtec.mn
Дансны дугаар: 417002978
Худалдаа хөгжлийн банк

Утас: 77778848
99 058429

САНХҮҮЖИЛТИЙН ХУВААРЬ

Гэрээний нийт үнийн дүн /492,000,000₮/	2020 онд санхүүжих дүн 100% /төгрөг/
1	2
492,000,000₮ /Дөрвөн зуун ерэн сая/	100%